



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/08

Чойр

Ёс зүйн зөвлөл байгуулах тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм батлах тухай" 33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ёс зүйн зөвлөлийн дарга:

Б.Нэргүйцэцэг

(Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Г.Дашжаргал

(Нийгмийн бодлогын хэлтсийн

Боловсрол, хүүхэд, гэр бүл,

залуучуудын бодлого хариуцсан

мэргэжилтэн)

Ц.Уранбаяр

(Хөгжлийн бодлого төлөвлөлт,

хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль

орчин, аялал, жуулчлал, ус цаг уур,

орчны шинжилгээ, уул уурхайн

бодлого хариуцсан мэргэжилтэн)

У.Занабазар

(Санхүү, төрийн сангийн хэлтсийн

Төсвийн ахлах мэргэжилтэн)

О.Болормаа

(Хяналт-шинжилгээ, үнэлгээний

хэлтсийн Дотоод аудит хариуцсан

ахлах мэргэжилтэн)

В.Баярсайхан

(Нийтлэг үйлчилгээний албаны

менежер)

Д.Оюунсайхан

(Төрийн захиргааны удирдлагын

хэлтсийн Дотоод ажил, өргөдөл,

Гишүүд:

Нарийн бичгийн дарга:

гомдол, санал, хүсэлт хариуцсан  
мэргэжилтэн)

2. Байгууллагын албан хаагчдад ёс зүйн дүрмийг мөрдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажиллахыг Ёс зүйн зөвлөл (Б.Нэргүйцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА \_\_\_\_\_ Д.СОДНОМ

